


**КИРГИЗСТАН: ГУЛЬЗАР ДУШЕНОВА**

**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ**



## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧ**

Гульзар Душенова бол тэмцэгч. 2002 онд автомашины ослын улмаас явж чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй болжээ. Дараа жил нөхөр нь зуурдаар нас барж, бага насны 2 хүүхэдтэйгээ үлдсэн байна.

Хэдэн жилийн дараа тэрээр Бишкек хотын нийслэлд зохион байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уулзалтад оролцжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ижилхэн асуудал тулгардаг нь тэргэнцэртэй иргэдийг ажилд авдаггүй, эсвэл автобус суулгалгүйгээр орхиж явдаг зэрэг нөгөө л нэг улир болсон ичгэвтэр зүйлс байдгийг тэр анзаарчээ.

Тэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөтэй зорчиж, нэр төртэй амьдрах

боломжтой болгохыг баталгаажуулах зорилго өмнөө тавьжээ. Холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, автобусны жолооч нарт сургалт явуулж, цахим орчинд идэвхтэй ажиллаж байв.

Гэхдээ түүнд саад бэрхшээл тулгарсаар байна. Шатаар доошоо бууж, хаалгаар гарахад нь туслах хүн шаардагдаж, зам нь шавартай, овон товон ихтэй тул өөрөө тэргэнцэртэйгээ явах боломжгүй байдаг. Эдгэршгүй өвчин туссан хөгжлийн бэрхшээлтэй хүн эсвэл эмгэглэгчүүд дуугарах ёсгүй гэсэн нийгмийн ялгаварлан гадуурхалттай өдөр бүр нүүр тулдаг.

Гэвч Гульзар дуугүй байхыг хүсээгүй. Түүнийг дэмжицгээе.



**Киргизстаний Парламентад  
хандан Гульзарын өөрчлөлтийн  
төлөөх тэмцлийг дэмжихийг  
уриална уу.**

Speaker of Parliament  
Chui Prospekti, 205  
Bishkek  
Kyrgyzstan 720000  
Email: [kenesh001@gmail.com](mailto:kenesh001@gmail.com)  
Salutation: Dear Speaker



**Гульзарыг дэмжиж байгаа эв  
санааны нэгдлээ илэрхийлээрэй**

■ Gulzar Duisheva  
■ c/o Amnesty International Ukraine  
■ POB 40  
■ 04050  
■ Kyiv  
■ Ukraine  
■ Email: [gulzarduisheva@gmail.com](mailto:gulzarduisheva@gmail.com)